



НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны хамтарсан 36/32 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл” (цаашид “Ёс зүйн зөвлөл” гэх)-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой байгууллага, иргэдээс ирүүлсэн гомдол мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэж ажиллахыг Ёс зүйн зөвлөлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын “Ёс зүйн зөвлөл шинэчлэн батлах тухай” 2020 оны А/142 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т.ОЮУНЧИМЭГ

111020000300

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2022 оны *03 дугаар* сарын
02-ны өдрийн *А.С. Дугар* тушаалын
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга
	Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн нарийн бичиг дарга
Нарийн бичгийн дарга	Төрийн албан хаагчийн ёс зүй, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн